

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ ҮНДСЭН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ЗАРИМ ОРНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОГТОЛЦООНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ЧИГ ҮҮРЭГ, БҮТЦИЙН ХАРЬЦУУЛСАН ЛАВЛАГАА

Г.Билгээ, Р.Оргилмаа, Д.Халиун

АГУУЛГА

1. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай, түүний үүсэл хөгжил
2. Хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан байгууллагыг Үндсэн хуулиар хуульчилсан байдал
3. Зарим орны хөгжлийн бодлого төлөвлөлтийн тогтолцооны зарим байгууллагуудын үндсэн чиг үүрэг, харьяалах субъект, бүтэц зохион байгуулалтын талаар

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Нэг. ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ТУХАЙ, ТҮҮНИЙ ҮҮСЭЛ ХӨГЖИЛ

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай

Хөгжлийн талаарх хамгийн өргөн хэрэглэгддэг тодорхойлолтод... “Өнөө үеийн хэрэгцээг хойч үеийн чадварыг бууруулахгүй байдлаар хангахтай холбогдсон зүйл” гэсэн байдаг. Энэ нь хүн бүрийн хэрэгцээг хүлээн зөвшөөрсөн нийгмийн дэвшил, хүрээлэн буй орчныг үр дүнтэй хамгаалах, байгалийн баялгийг сэтгэлийн хөөрлөөр биш харин болгоомжтой, ухаалгаар ашиглах, эдийн засаг, ажил эрхлэлтийг тогтвортой, өндөр төвшинд явч явах явдал юм. Ингэхдээ хөгжлийн алтан гурвалжин болох нийгмийн тэгш байдал, эдийн засгийн өсөлт, хүрээлэн буй орчныг хамгаалах асуудлуудыг ямагт анхаарлынхаа төвд, тэнцвэртэй байлгаж байна.

Хөгжлийн төлөвлөлт нь тухайн улс орны хэтийн стратеги зорилтод тусгагдсан тогтвортой хөгжлийн зарчмуудтай нийцсэн, нэгдмэл байдлаар хийгдэх ёстой. Бүс нутгийн төлөвлөлтийн байгууллагууд болон орон нутгийн удирдлагууд дээрх хөгжлийн төлөвлөлттэй байнга зэрэгцэн явах учиртай бөгөөд хүрээлэн буй орчин, эдийн засаг хийгээд нийгмийн зорилтод хүрэхэд дорвитой түлхэц үзүүлдэг. Ялангуяа тулгараад байгаа уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан, боломжит нөлөөллийг бууруулахад бүс нутгийн төлөвлөлтийн байгууллагууд, орон нутгийн удирдлагууд чухал үүрэгтэй.²⁵⁰

²⁵⁰“Дэлхийд хөгжлөөрөө тэргүүлэгч зарим орны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн арга, туршлага” УИХ-ын Тамгын газрын Судалгаа, шинжилгээний хэлтэс СТ-13/239

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль (2015)

2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр батлагдсан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд “хөгжлийн бодлого төлөвлөлт”²⁵¹ гэсэн нэр томьёо, түүний тайлбар байхгүй, харин “аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл”, “аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт”, “бүсчилсэн хөгжлийн бодлого”, “дэд хөтөлбөр”, “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”, “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр”, “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал”, “төрөөс баримтлах бодлого”, “улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”, “улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл”, “үндэсний хөтөлбөр”, “хөгжлийн бодлогын баримт бичиг” зэргийн нэр томьёог тусгасан байна. Хуулийн 5 дугаар зүйлд хөгжлийн бодлого төлөвлөлтөд баримтлах зарчмыг дараах байдлаар тодорхойлсон байна:

- 5.1.1.үндэсний язгуур эрх ашигт нийцсэн байх;
- 5.1.2.нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;
- 5.1.3.төрийн бодлогын залгамж чанарыг хадгалсан байх;
- 5.1.4.судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;
- 5.1.5.нөөц бололцоонд үндэслэсэн байх;
- 5.1.6.ил тод, нээлттэй байх;
- 5.1.7.олон нийтийн оролцоог хангасан байх.

“Гурван тулгуурт хөгжлийн бодлого” батлах тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоол (2018)

“Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ыг Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтууд (2015-2030), Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засгийг сэргээх хөтөлбөр, Хөгжлийн зам хөтөлбөртэй уялдуулан боловсруулсан бөгөөд дэлхий нийтийн хөгжлийн хандлага болон хөрш орнуудын эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, Монгол Улсын хөгжлийн боломж, сорилтыг олон улсын индексүүдэд тулгуурлан тодорхойлжээ.

Гурван тулгуурт хөгжлийн бодлого нь Монгол Улсын 2018-2020 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн суурь баримт бичиг юм. Тус хөтөлбөр нь бодлогод тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн тооцоог эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчилж төлөвлөсөн баримт бичиг болно.

Энэхүү бодлогод Монгол Улсын хөгжлийн үндэс нь сайн төр, монгол хүн, монголын баялаг гэж үзэн “Нэгдмэл зорилготой Монгол Улс” үзэл баримтлалын дор “Олон тулгуурт эдийн засгийн хөгжлийн бодлого”, “Шударга ёсыг дээдэлсэн, сахилга, хариуцлагатай тогтвортой засаглал”, “Хүн төвтэй нийгмийн бодлого” гэсэн гурван тэргүүлэх чиглэлийг байгаль орчинд ээлтэй байдлаар төлөвлөж, хэрэгжүүлэх 27 зорилтыг тусган байна.

²⁵¹Хуулийн төсөлд “хөгжлийн бодлого төлөвлөлт”-ийг Монгол Улсын хөгжлийн бодлого, чиглэлийг тодорхойлох, түүнд шаардагдах нөөцийн хуваарилалтыг судалгаа, шинжилгээнд үндэслэн төлөвлөх үйл явцын нэгдлийг ойлгоно гэж заасан байсан нь хасагдсан байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн үүсэл, хөгжил

1950-60-аад онд шинээр тусгаар тогтносон улс орнуудын хувьд үндэсний хөгжлийн төлөвлөгөө нь тусгаар тогтнолын нэгэн бэлэг тэмдэг болж байсан гэж хэлж болох юм. Тухайн үед эдийн засгийн “төрийн зохицуулалт” (Arrow, 1963, Coase, 1960, Keynes, 1931, Keynes, 1936, Polanyi, 1957, Robinson, 1933, Samuelson, 1954), эсхүл социалист загвар (5 жилийн төлөвлөгөө гм)²⁵² -ын үзэл санаа давамгайлж байсан ба үндэсний хөгжил, үндэсний хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд гол зохицуулах үүргийг төр гүйцэтгэх ёстой гэж үзэж байсан. Улс орнуудад НҮБ, түүний агентлагууд, санхүүгийн институциуд болох Дэлхийн банк болон бүс нутгийн хөгжлийн банкууд холбогдох дэмжлэгийг үзүүлж, Нобелийн шагналтан, эдийн засагч Артур Льюис зэрэг нь хөгжлийн эдийн засаг, хөгжлийн төлөвлөлттэй холбоотой асуудлаар идэвхтэй ажиллаж, 1965 онд Дэлхийн банкнаас “Хөгжлийн төлөвлөлт: туршлагаас авах сургаж” зэргийг нийтэлсэн байна.

Харин 1970-аад оноос үүссэн системийн шинжтэй эдийн засгийн томоохон хямрал болон бусад гадаад болон дотоод хүчин зүйлээс үүдэн дээрх үзэл санаа нь хүчээ алдаж эхэлсэн бөгөөд зарим нь улс төрийн хүсэл зориг дутсан, зохистой тоо мэдээ, тооцоолол, төлөвлөлт хийх чадавх (төлөвлөлтийн онол болон хэрэгжилтийн уялдаа холбоо хангалтгүй) дутсан (Faber & Seers, 1972) зэрэг шүүмжлэлүүд ихээр гарах болсноос гадна тухайн үеийн эдийн засгийн тогтворгүй байдал нь хэтийн төлөвлөлтийг хүндрүүлж, улмаар сонирхох сонирхлыг бууруулахад нөлөөлсөн байна. Мөн тухайн үеэс “government failure” төрийн оролцооны гажуудал²⁵³, “public choice theory” нийтийн сонголтын онол, “rent seeking” буюу ашиг хонжоо хайгчийн онол²⁵⁴ зэрэг онол, үзэл санаа онолууд дэлгэрсэн байдаг.

1980-аад оноос социалист блокийн задрал, Хятадын эдийн засгийн нээлттэй бодлого явуулж эхэлсэн зэрэг нь үндэсний хөгжлийн төлөвлөлт нь шаардлагатай, зохимжтой эсэхийг эргэж харахад хүргэсэн байна. ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улс орнууд 1990-2000-аад оны хооронд төлөвлөлтийн бүтэц, нэгжүүдээ татан буулгасан бол зээл тусламжаас хараат улс орнуудын хувьд “бүтцийн өөрчлөлтийн” хүрээнд төлөвлөлт хариуцсан агентлагууд, эдийн засгийн төлөвлөлтийн яамд нь 1980-1990-ээд оны хооронд татан буугдсан, эсхүл сангийн яамны бүтцэд орсон байна. Гэвч энэ нь үндэсний хөгжлийн төлөвлөлт бүр мөсөн алга болсон гэсэн үг биш бөгөөд Хятад, Энэтхэг, Малайз зэрэг орнууд нь эдийн засгаа либералчилсан хэдий ч үндэсний хөгжлийн аппаратуудаа хадгалж үлдсэн байна.

1996 оноос эхлэн Өрийн хэмжээ их, ядуу буурай орнууд Heavily Indebted Poor Country (HIPC)-ын санаачилгын хүрээнд хүлээн авагч улс орнууд эрүүл мэнд, боловсрол, хоол тэжээл болон ядуурлыг бууруулахад чиглэгдсэн хөрөнгө

²⁵² Дэлхийн II дайнаас өмнө дэлхийн дахинаа хөгжлийн системчилсэн төлөвлөлтийг нэврүүлсэн ганцхан улс байсан ЗХУ бөгөөд анхны 5 жилийн төлөвлөгөөг 1929 онд баталсан байна.

²⁵³ <https://www.sciencedirect.com/topics/economics-econometrics-and-finance/government-failure>

²⁵⁴ <https://www.sciencedirect.com/topics/social-sciences/rent-seeking>

оруулалт оруулах тохиолдолд өрийг хөнгөлөх тохиролцоонууд хийгдэж ирсэн бөгөөд зээлдэгч нараас хүлээн авагч орнуудад ядуурлыг бууруулах стратеги, ядуурлын эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээ, хөрөнгө оруулалт болон ядуурлын хэмжээг үнэлэх, тооцох арга хэрэгсэлтэй байхыг шаардлага болгосон байна. Мөн үеэс Дэлхийн банк (Ерөнхийлөгч Жеймс Вулфенсон)-ны зүгээс хөгжиж буй орнуудад Comprehensive development framework-тай байхыг уриалж эхэлсэн бөгөөд үр дүнд нь 2001 он гэхэд Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичгийг (PRSP) 63 улс баталсан байна. Дээрх Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичгийг нь нийгмийн салбаруудын хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, орц, гарц, үр дүнгийн матриц зэрэг олон талаар хуучны загварын үндэсний хөгжлийн төлөвлөгөөтэй төстэй байсан ба төлөвлөлтийг “сайн засаглалтай” уялдуулах зорилгоор оролцооны үнэлгээг нэвтрүүлсэн байна. Улс орнууд PRSP-г боловсруулсны дараагаар (Бангладеш, Бенин, Гана, Малави, Того, Уганда, Вьетнам, Замби зэрэг) Мянганы хөгжлийн зорилт болон бусад зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үндэсний төлөвлөгөөтэй болж эхэлсэн байна. Тус үеэс эхлэн “asymmetric information” мэдээллийн тэгш бус байдал (Barr, 1992), “behavioural economics” зан төлөвийн эдийн засаг зэрэг нь (Kahneman, 2011, Thaler and Sunstein, 2009) зах зээлийн өөрийгөө зохицуулах механизмын алдаа дутагдалтай талуудыг ил гаргаж, хөгжлийн төлөвлөлт дахин сэргэх хандлагууд ажиглагдаж ирсэн байна.

2007 онд Дэлхийн банкнаас гаргасан судалгаанд дэлхийн 62 улс орон үндэсний хөгжлийн төлөвлөгөө (National Development Plan)-тэй байсан бол 2016-2017 онд давтан явуулсан судалгаагаар дээрх тоо хоёр дахин буюу 134 улс болж нэмэгдсэн байна.

Үндэсний хөгжлийн төлөвлөлтийн дахин сэргээлтийн шалтгаан нь юу вэ?

Үндэсний хөгжлийн төлөвлөлтийг улс орнууд дахин сэргээх болсон шалтгааныг судалж үзэхэд дараах байдалтай байна. Нэгдүгээрт, Ядуурлыг бууруулах бичиг баримтыг баталсан хөгжиж буй дийлэнх улс орнууд үндэсний хөгжлийн төлөвлөлттэй болсон байна. Дээр дурдсан 63 улсаас 52 нь “ядуурлыг бууруулах” үндсэн чиглэлээс давсан үндэсний хөгжлийн төлөвлөгөөтэй болсон бол 11 улс нь шинэ загварын/үеийн Ядуурлыг бууруулах бичиг баримттай болсон байна. Гана, Уганда, Бенин болон Того зэрэг улсын Ядуурлыг бууруулах бичиг баримтыг хэрэгжүүлсэн туршлага нь төрийн төлөвлөлтийн чадавхыг нэмэгдүүлж, төлөвлөлт, төлөвлөгөөний ач холбогдлыг мэдрүүлж, ядуурал болон хүний хөгжлийн асуудлыг салбарын асуудал хариуцсан яам дангаараа бус, харин сангийн яамтай хамтран хариуцахын ач холбогдлыг харуулсан байна. Хоёрдугаарт, 2000 оны МХЗ болон 2015 оны ТХЗ зэрэг хөгжлийн томоохон зорилтуудыг хэрэгжүүлэхэд төлөвлөлт, хяналт шинжилгээний механизмууд хэрэгтэй болсон байна.

Хоёр. ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГЫГ ҮНДСЭН ХУУЛИАР ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал хариуцсан байгууллагыг Үндсэн хуулиар хуульчилсан улс орнуудаас 13 улс орны зохицуулалтыг байгууллагын харьяалал, бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, удирдлага болон гишүүдийг томилдог субъект, удирдлага болон гишүүдийн бүрэн эрхийн хугацаа зэргээр багцалбал дараах байдалтай байна:

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн институт нь:

- Ерөнхийлөгчийн харьяанд: Гана, Уругвай, Намиби;
- Парламентаас шийдвэрлэх: Лесото;
- Хараат бус, бие даасан агентлаг: Филиппин.

Тус байгууллагын удирдлага болон гишүүдийг томилох, сонгох субъект:

- Ерөнхийлөгч томилдог: Гана, Колумб, Уругвай, Йемен, Намиби;
- Орон нутгийн иргэдийн хурлаас сонгодог: Кабо-Верде.

Байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг Үндсэн хуульдаа тусгасан:

- Гана, Колумб, Уругвай, Эквадор, Кабо-Верде.

Байгууллагын чиг үүргийг нарийвчлан зохицуулсан:

- Гана, Колумб, Уругвай, Эквадор, Йемен.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн институттай байна гэж заасан:

- Турк, Намиби, Португал, Уганда, Испани.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан улс орнуудын засаглалын хэлбэр

Төрийн удирдлагын хэлбэр	Улсын тоо	Улс орны нэр
Ерөнхийлөгчийн засагтай	6 улс	Гана, Колумби, Турк, Уругвай, Филиппин Эквадор
Хагас Ерөнхийлөгчийн засагтай	5 улс	Кабо-Верде, Йемен, Намиби, Португал Уганда
Парламентын хаант засагтай	2 улс	Испани, Лесото

**Хүснэгт 2. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн институцийн талаарх
Үндсэн хуулийн зүйл, заалт**

Д/д	Улсын нэр	Үндсэн хуулийн заалт
Ерөнхийлөгчийн засаглалтай		
1.	Гана	<p>86 дугаар зүйл. <u>Үндэсний хөгжил, төлөвлөлтийн хороо</u></p> <p>2.Ерөнхийлөгч нь Төрийн зөвлөлтэй зөвлөлдсөнөөр тус хорооны даргыг томилно. Хорооны гишүүд нь Сангийн сайд болон Ерөнхийлөгчийн санал болгосон бусад сайд нар, Засгийн газрын статистикч, Гана улсын банкны захирал, Бүс нутгийн зохицуулах зөвлөлөөс санал болгосон бүс нутаг бүрийн төлөөлүүд болон Ерөнхийлөгчийн санал болгосон эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны хөгжил, төлөвлөлтийн асуудлаар мэргэшсэн хүмүүсээс бүрдэнэ.</p> <p>3.Хороо нь Ерөнхийлөгчийн харьяанд байна.</p> <p>87 дугаар зүйл.</p> <ul style="list-style-type: none"> • Хороо нь Ерөнхийлөгчид хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар зөвлөх үүрэгтэй. • Хороо нь Ерөнхийлөгч, парламент болон өөрийн санаачилгаар хөгжлийн бодлого, хэтийн төлөвийг тандсан судалгаа хийж, үнэлэлт дүгнэлт гаргана. • Хөгжлийн бодлого, хөтөлбөр, төслүүдэд хяналт тавьж, үнэлгээ хийнэ.
2.	Колумб	<p>340 дүгээр зүйл.</p> <p>Тус улс нь <u>Үндэсний төлөвлөлтийн зөвлөлтэй</u> байна.</p> <p>Үндэсний төлөвлөлтийн зөвлөл нь нутаг дэвсгэрийн нэгжүүд болон эдийн засаг, нийгэм, соёл, байгаль экологийн салбаруудын төлөөлүүдээс бүрдсэн бүтэцтэй байна. Тус зөвлөл нь Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хэлэлцэн, зөвлөх чиг үүрэгтэй байна. Салбар бүрээс нэр дэвшүүлсэн Үндэсний төлөвлөлтийн зөвлөлийн гишүүдийг Ерөнхийлөгч томилно. Гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 8 жил байх бөгөөд хуульд зааснаар 4 жилд 1 удаа гишүүдийг хэсэгчлэн шинээр томилж байна. Хуульд зааснаар орон нутгийн захиргааны нэгжүүд нь төлөвлөлтийн зөвлөлүүдтэй байна. Үндэсний төлөвлөлтийн зөвлөл болон орон нутаг дахь төлөвлөлтийн зөвлөлүүд нь Үндэсний төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлнэ.</p>
3.	Турк	<p>166 дугаар зүйл.</p> <p>Хөгжлийн төлөвлөлт, хэрэгжүүлэх зарчим, үйл ажиллагааг Турк улсын Үндэсний Ассамблей батална. Хөгжлийн төлөвлөлтийн хэрэгжилт, хяналтыг хуулиар тогтооно.</p> <p>Эдийн засаг болон нийгмийн бодлогыг тодорхойлох, Ерөнхийлөгчид зөвлөх үүрэг бүхий <u>Эдийн засаг болон Нийгмийн Зөвлөлийн</u> бүтэц, чиг үүргийг хуулиар тогтооно.</p>
4.	Уругвай	<p>230 дугаар зүйл.</p> <p><u>Төлөвлөлт болон төсвийн алба</u> нь Ерөнхийлөгчийн шууд харьяан дор үйл ажиллагаагаа явуулна. Тус албаны даргыг Ерөнхийлөгч томилно. Алба нь хөгжлийн бодлоготой холбоо бүхий салбарын сайд нараас бүрдсэн хороотой байна.</p> <p>Төлөвлөлт болон төсвийн алба нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ яамд болон төрийн бусад байгууллагатай шууд харьцана.</p> <p>Төлөвлөлт болон төсвийн алба нь ажилчид, төрийн бусад байгууллага болон хувийн хэвшлийн төлөөллөөс бүрдсэн Хэсгийн хороодтой байна. Тус алба нь хөгжлийн төлөвлөгөө болон хөтөлбөрүүдийг боловсруулж, хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана.</p>

5.	Филиппин	12 дугаар хэсэг. 9 дүгээр зүйл. Эдийн засаг болон үндэсний баялаг Конгресс нь Ерөнхийлөгчөөр удирдуулсан эдийн засаг, төлөвлөлтийн бие даасан агентлагийг байгуулж болно. Тус агентлаг нь төрийн бусад агентлагууд, орон нутгийн засаг захиргааны болон хувийн хэвшлийн байгууллагуудтай харилцан зөвшилцсөний үндсэн дээр Үндэсний хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. Конгресс өөрөөр заагаагүй бол <u>Үндэсний эдийн засаг, хөгжлийн газар</u> нь засгийн газрын бие даасан агентлаг байж, чиг үүргээ хэрэгжүүлнэ.
6.	Эквадор	279 дүгээр зүйл. <u>Үндэсний төлөвлөлтийн зөвлөл</u> нь шат шатны нутгийн захиргааны нэгжийн төлөөллүүд, ард иргэдийн төлөөллөөс бүрдэнэ. Тус зөвлөл нь өөрийн ажлын албатай байна. Тус зөвлөл нь Үндэсний хөгжлийн бодлогыг батлах, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн системийг удирдах, чиглүүлэх чиг үүрэгтэй. Зөвлөлийг Ерөнхийлөгч даргална.
Хагас Ерөнхийлөгчийн засаглалтай		
7.	Кабо-Верде	2 дугаар бүлэг. <u>Бүс нутгийн асуудал хариуцсан зөвлөл</u> 281 дүгээр зүйл. Бүтэц1.Зөвлөл нь орон нутгийн иргэдийн хурлаас сонгогдсон арал тус бүрийн 2 төлөөлөгчөөс бүрдэнэ. 2. Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 4 жил байна. 282 дугаар зүйл. 1.Зөвлөл нь өөрийн гишүүдийн болон Үндэсний Ассамблей, Ерөнхийлөгч, Засгийн газрын санаачилсан бүс нутгийн хөгжилтэй холбоотой бүхий л асуудалд зөвлөх үүрэгтэй байна. 2.Зөвлөл нь Үндэсний хөгжлийн бодлого, Бүс нутгийн хөгжлийн бодлого болон орон нутгийн хөгжил, санхүүтэй холбоотой Засгийн газрын төсөл, баримт бичигт зайлшгүй өөрийн саналыг тусгасан байна. 3.Зөвлөлийн эрх мэдэл, чиг үүрэг, дотоод үйл ажиллагааг хуулиар тогтооно.
8.	Йемен	125 дугаар зүйл. <u>Зөвлөлдөх зөвлөл</u> Зөвлөлдөх зөвлөлийг Ерөнхийлөгчийн зарлигаар байгуулна. Зөвлөл нь Үндсэн хуульд заасан эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна. 126 дугаар зүйл. Зөвлөл нь (111) гишүүнээс бүрдэнэ. Зөвлөлийн гишүүдийг Ерөнхийлөгч шууд томилно. Гишүүдийг эдийн засаг, нийгмийн салбарын мэдлэг, туршлага бүхий хүмүүсээс бүрдүүлнэ. Зөвлөлдөх зөвлөлд Төлөөлөгчдийн танхимын гишүүд болон орон нутгийн зөвлөлийн гишүүдийг орохыг хориглоно. Зөвлөлийн хэрэгжүүлэх чиг үүрэг, хариуцлага, эрх мэдлийн хүрээ, гишүүдийн ажиллах нөхцөл зэргийг хуулиар тогтооно. Зөвлөл нь өөрийн дотоод журмыг боловсруулж, мөрдөж ажиллана.
9.	Намиби	129 дүгээр зүйл. <u>Үндэсний төлөвлөлтийн хороо</u> 1.Тус хороо нь Ерөнхийлөгчийн харьяанд байна. Төлөвлөлтийн хороо нь үндэсний хөгжлийн бодлогын чиглэл болон тэргүүлэх асуудлыг төлөвлөнө. 2.Хороог Ерөнхийлөгчийн томилгоогоор Ерөнхий захирал тэргүүлнэ. Ерөнхий захирал нь эдийн засгийн төлөвлөлттэй холбоотой бүхий л асуудалд Ерөнхийлөгчийн ерөнхий зөвлөх байна. 3.Үндэсний төлөвлөлтийн хорооны гишүүд, эрх мэдэл, чиг үүрэг болон ажлын албыг Парламентын тухай хуулиар зохицуулна.
10.	Португал	92 дугаар зүйл. <u>Эдийн засаг, нийгмийн зөвлөл</u> Зөвлөл нь эдийн засаг, нийгмийн бодлогыг хэлэлцэх, эдийн засаг, нийгмийн хөгжлийн төлөвлөлт болон хэрэгжүүлэх үйл явцыг тодорхойлох үндсэн үүрэг бүхий байгууллага болно. Хуульд заасан бусад үүргийг мөн хэрэгжүүлнэ. 2.Зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн нь хуульд заасны дагуу Засгийн газар болон төрийн бусад байгууллагын төлөөллөөс бүрдэнэ. 3.Зөвлөлийн бүрэн эрх, чиг үүргийг хуулиар тогтооно.

11.	Уганда	125 дугаар зүйл. Тус улс нь <u>Үндэсний төлөвлөлтийн газартай</u> байна. Үндэсний төлөвлөлтийн газрын бүтэц, чиг үүргийг парламентаас тогтооно.
Парламентын хаант засаглалтай		
12.	Испани	131 дүгээр хэсэг. 2.Засгийн газар нь Орон нутгийн засаг захиргааны байгууллагуудаас гаргасан урьдчилсан тооцоон дээр үндэслэн төлөвлөлтийн хөтөлбөрийн төслийг боловсруулна. <u>Төлөвлөлтийн төслийг хэрэгжүүлэх зөвлөлийг</u> байгуулж ажиллана. Зөвлөлийн гишүүнчлэл болон чиг үүргийг хуулиар тогтооно.
13.	Лесото	105 дугаар зүйл <u>Үндэсний зөвлөх төлөвлөлтийн хороо</u> . Хороо нь нийт 18 гишүүнээс бүрдэнэ. Хороо нь тухайн салбарын сайд нарт хөгжлийн бодлогын талаар зөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй. Үндэсний зөвлөх төлөвлөлтийн хорооны даргын сонгууль, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа, хорооны чиг үүргийг парламентаас тогтооно.

Хүснэгт 3. Зарим орны хөгжлийн бодлого төлөвлөлтийн удирдлагын тогтолцооны зарим байгууллагуудын үндсэн чиг үүрэг

Улсын нэр	Байгууллагын нэр	Тодорхойлох	Төлөвлөх/ Боловсруулах	Хяналт тавих/ Үнэлгээ хийх	Тайлбар
1.Латви улс	Тогтвортой хөгжлийн байнгын хороо (Парламент)			✓	Нийгмийн хамтрагчдын үйл ажиллагаа ба ТББ зэрэг нийгмийн оролцоотой хяналтыг хэрэгжүүлнэ
	Хөгжлийн үндэсний зөвлөл (Засгийн газар)			✓	
	Тогтвортой хөгжлийн институт “Латви-2030”			✓	
	Сайд нарын танхим, Яамд, Бүс нутаг болон нутгийн өөрөө удирдах байгууллага		✓		
2.Малайз лс	Үндэсний төлөвлөлтийн зөвлөл	✓	✓	✓	Шийдвэр гаргах түвшинд
	Үндэсний хөгжлийн төлөвлөлтийн хороо	✓	✓	✓	
	Эдийн засгийн төлөвлөлтийн товчоо	✓	✓	✓	Судалгаа хийх, бэлтгэл ажлыг хангах, удирдан чиглүүлнэ
3.Солонгос улс	Ерөнхийлөгчийн дэргэдэх Тогтвортой хөгжлийн комисс		✓	✓	
4.Турк	Хөгжлийн яам				

Хүснэгт 4. Зарим орны хөгжлийн бодлого төлөвлөлтийн тогтолцооны зарим байгууллагуудын үндсэн чиг үүрэг, харьяалах субъект, бүтэц зохион байгуулалт

<i>Байгууллагын нэр</i>	<i>Үндсэн чиг үүрэг</i>	<i>Харьяалах субъект</i>	<i>Бүтэц, зохион байгуулалт</i>
1.ЛАТВИ УЛС			
1) Тогтвортой хөгжлийн хороо (Sustainable Development Commission)	<ul style="list-style-type: none"> - Тус улсын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль 2009.01.01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Сеймээс “Латви-2030” тогтвортой хөгжлийн стратегийг 2010.06.10-ны өдөр баталсан. - 2014 онд Латвийн Сейм (Парламент) нь үндэсний стратегийн төлөвлөлтийн хүрээг тогтоох парламентын хяналт бүхий Тогтвортой хөгжлийн хороог байгуулсан. - Тус Хороо нь “Латви-2030” тогтвортой хөгжлийн стратеги, Үндэсний хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, Засгийн газрын бодлогын дунд, урт хугацааны үр нөлөө, Засгийн газрын төсвийн бодлогын тогтвортой байдлыг хангахад хяналт тавина. - Сейм 2 жил тутамд нэг удаа “Латвия-2030” тогтвортой хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх Сайд нарын танхимын илтгэлийг хэлэлцүүлнэ. Мэдээллийн үндсэн дээр Сейм стратегийн зорилтуудад зарим өөрчлөлт оруулах талаар шийдвэрийг гаргаж болно. 	Сейм (Парламент)	Хорооны бүрэлдэхүүнд 17 Сеймийн гишүүн багтана.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

<p>2) Хөгжлийн үндэсний зөвлөл (National Development Council)</p>	<ul style="list-style-type: none"> - Энэхүү хамтарсан зөвлөх эрх бүхий байгууллага нь улс орны урт хугацааны хөгжлийн төлөвлөлт, үнэлгээг хийхдээ төсөв, бодлогын төлөвлөлтийг зохицуулах бүтцийн шинэчлэлийг санаачилж, түүнчлэн үндэсний болон орон нутгийн төрийн бодлогын уялдаа холбоог хангана. - Төлөвлөлт хэрэгжилтэд хяналт тавина. 	<p>Ерөнхий сайд</p>	<p>Ерөнхий сайд даргална. Зөвлөлийн гишүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Эко-эдийн засгийн сайд, - Байгаль орчныг хамгаалах болон Бүс нутгийн хөгжлийн сайд, - Сангийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, - ажил олгогч, үйлдвэрчний эвлэл, - Латви Улсын орон нутгийн засаг захиргааны холбооны дарга, - Латви Улсын Ерөнхийлөгчийн төлөөлөгч
<p>3) Тогтвортой хөгжлийн институт “Латви-2030” (Sustainable Development Institute “Latvia 2030”)</p>	<p>Үндсэн зорилт: Сайд нарын танхим, Сеймд танилцуулах улс орны тогтвортой хөгжил, “Латвия-2030” стратегийн хэрэгжилт, Үндэсний хөгжлийн хөтөлбөрийн талаарх илтгэлийг бэлтгэх явдал юм. Түүнээс гадна тус институт нь улс төрийн хариуцлагатай шийдвэр гаргахад шаардлагатай төрийн стратегийн чухал асуудлуудыг судалж, үндэслэлтэй зөвлөмж гаргах судалгааны найдвартай баазыг бий болгох, төрийн мөнгөний бодлого нь батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөө, тогтвортой хөгжлийн зарчимд нийцэж буй эсэхэд үнэлгээ хийх, нийтийн удирдлагын байгууллагууд, иргэний нийгэм, эрдэмтэд, судлаачдын хамтын ажиллагаа, эрдэм шинжилгээний хэлэлцүүлгийг өрнүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг зорилготой.</p>		

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

2.МАЛАЙЗ УЛС			
1) Үндэсний төлөвлөлтийн зөвлөл (National Planning Council)	Хөгжлийн төлөвлөлтийн асуудал эрхэлсэн дээд түвшний байгууллага	Ерөнхий сайд	Зөвлөлийн гишүүд: <ul style="list-style-type: none"> - сангийн сайд - олон улсын худалдаа, аж үйлдвэрийн сайд - дотоод худалдааны сайд - бизнесийн хөгжлийн сайд - бараа таваар, хөдөө аж ахуйн сайд
2) Үндэсний хөгжлийн төлөвлөлтийн хороо (National Development Planning Committee)	1)Хөгжлийн төлөвлөлтийн бодлогыг тодорхойлох, нарийвчлан хэлэлцэх дээд байгууллага 2)Хөгжлийн төлөвлөгөөг <ul style="list-style-type: none"> - боловсруулах - хэрэгжүүлэх - хянаж үнэлэх - тодруулах - хэрэгжилтэнд хяналт тавих - нөөцийг хуваарилах талаар зөвлөмж гаргана. 	Ерөнхий сайд	<ul style="list-style-type: none"> - Хороо нь Засгийн газрын ахлах албан тушаалтнуудаас бүрдэх ба Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга тэргүүлнэ <p>Хорооны гишүүд нь эдийн засгийн хөгжлийн чиглэлийн бүх яамдын сайд нар, Төв банкны ерөнхийлөгч байна.</p>
3) Эдийн засгийн төлөвлөлтийн товчоо (Economic Planning Unit)	Чиг үүрэг: <ol style="list-style-type: none"> 1) Төлөвлөлт <ul style="list-style-type: none"> - нийгэм-эдийн засгийн судалгаа, анализ - хөгжлийн бодлого - макро эдийн засгийн загварчлал, тогтолцоо - хөгжлийн төлөвлөгөө 2) Нөөцийн хуваарилалт <ul style="list-style-type: none"> - төсвийн удирдлага, төслийн үнэлгээ 3) Хяналт-шинжилгээ <ul style="list-style-type: none"> - үндэсний хөтөлбөрүүдийн хяналт-шинжилгээ - санал, санаачлагын хяналт-үнэлгээ - төслийн хяналт-үнэлгээ <p>Үйл ажиллагаа:</p> <ul style="list-style-type: none"> - Нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого, стратегийг томъёолох - Дунд болон урт хугацааны төлөвлөгөөг бэлтгэх - Хөгжлийн хөтөлбөр, төслүүдийн төсвийг бэлтгэх - Хөгжлийн хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилтэнд хяналт, үнэлгээ хийх - Засгийн газарт эдийн засгийн асуудлаар зөвлөлтөө өгөх 	Ерөнхий сайд	<ul style="list-style-type: none"> - Ерөнхий сайдын өмнө ажлаа шууд хариуцан тайлагнана - Удирдлагын бүтэц: ерөнхий захирал, түүний 3 орлогч - Удирдлагад нь Малайзын хөгжлийн хүрээлэн (Malaysian Development Institute) ажиллана - Үйл ажиллагаанд нь Ерөнхий сайдын дэргэдэх төв агентлаг болох Хэрэгжилт, зохицуулалтын товчоо (Implementation and Coordination Unit), Малайзын засаг захиргаа, шинэчлэлийн товчоо (Malaysian Administrative and Modernization Planning Unit) дэмжиж ажиллана.

	<ul style="list-style-type: none"> - Шаардлагатай эдийн засгийн судалгааны ажлыг санаачлах, гүйцэтгэх - Хувьчлалын хөтөлбөрүүдийг төлөвлөх, зохицуулах, хэрэгжилтэнд нь үнэлгээ хийх - Олон талт хөгжлийн хөтөлбөр дэх Малайзын оролцоог хангах 		
3.СОЛОНГОС УЛС			
1) Ерөнхийлөгчийн дэргэдэх Тогтвортой хөгжлийн комисс (Presidential Commission on Sustainable Development)	<p>Чиг үүрэг:</p> <ul style="list-style-type: none"> - тогтвортой хөгжлийн зорилго, бодлого стратегийг боловсруулах - Ерөнхийлөгчийг бодлогын зөвлөгөөгөөр хангах, санамж бичгүүдийг боловсруулах - Тогтвортой хөгжилтэй холбоотой нийгмийн зөрчил маргааныг шийдвэрлэх, хяналтын менежментийн тогтолцоог бий болгох <p>Үйл ажиллагаа:</p> <ul style="list-style-type: none"> - салбарын асуудлуудтай холбоотой бодлого боловсруулж Ерөнхийлөгчид өргөн барих - чухал ач холбогдолтой үндэстний урт, дунд хугацааны төлөвлөгөөг улсын бодлогын тогтвортой байдлын үүднээс нь урьдчилан нягтлаж үзэх - зөрчлийн менежмент, урьдчилан сэргийлэх тогтолцоог хөгжүүлэх, цаг үеийн олон нийтийн элдэв зөрчилдөөний үед Ерөнхийлөгчид нийгмийн эв зөийг хэрхэн хангах тухайд зөвлөх. <p>Хяналт, үнэлгээ-мониторинг: Улсын тогтвортой хөгжлийн бодлогын хэрэгжилтийг гурван түвшний схемээр хянаж үнэлгээ хийнэ:</p>	Ерөнхийлөгч	<p>2000 онд Ерөнхийлөгчийн зарлигаар байгуулагдсан. Удирдах хороо - 35 гишүүнтэй. Мэргэжлийн хороод, судалгааны багуудын бодлогын саналыг нягтлан үзэх, Ерөнхийлөгчид зөвлөх үүрэгтэй.</p> <p>Зөрчлийг зохицуулах тусгай хороо - 50 гишүүнтэй: Удирдах Хорооноос томилогдсон болон муж улсууд, ТББ-уудаас санал болгосон бусад гишүүд багтана. Зөрчлийн менежмент, урьдчилан сэргийлэх тогтолцоог боловсруулан хөгжүүлж, Удирдах хорооноос цаг үеийн олон нийтийн зөрчлийн асуудлаар өгсөн даалгаврын дагуу Ерөнхийлөгчид зөвлөнө.</p> <p>Мэргэжлийн 4 хороо (МХ) - Удирдах хорооны тодорхой хувь болон холбогдох мэргэжилтнүүдээс бүрдэнэ. Судалгааны багуудыг ажиллуулна. Салбар судлагдахуун тус бүр дээр бодлогын санал боловсруулна.</p> <ul style="list-style-type: none"> - Нийгэм, эрүүл мэндийн МХ; - Байгаль орчин, дэд бүтцийн МХ; - Эрчим хүч, үйлдвэрлэлийн МХ; - Тогтвортой хөгжлийн хэрэгжилтийн МХ. <p>Төлөвлөлтийн менежментийн газар - удирдах хорооны гишүүд байна.</p>

	<p>1/ сайн дурын үндсэн дээр; 2/ Засгийн газраас Ерөнхий сайдын дэргэдэх Засгийн газрын бодлого зохицуулалтын газартай зөвлөлдөн тодорхой төлөвлөгөөний дагуу 2 дугаар түвшний буюу төв Засгийн газрын түвшний мониторингийг хэрэгжүүлнэ. 3/ Тогтвортой хөгжлийн бодлогын хэрэгжилтийг түүний индикаторын дагуу хянаж үнэлгээ хийнэ.</p>		
2.ТУРК УЛС			
1) Хөгжлийн яам	<p>Үндсэн хууль болон бусад хуулиар хүлээсэн дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> - эдийн засаг, нийгэм, хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлоход Засгийн газарт мэргэжлийн зөвлөгөө өгөх - бусад яамдын бодлого, үйл ажиллагааны хамтын ажиллагаа, уялдааг зохицуулах - хөгжлийн төлөвлөгөө, дунд болон богино хугацааны хөтөлбөр, хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах - макро түвшний салбарын, бүсийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах - улсын хөрөнгө оруулалтад суурилсан стратегийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох - бодлогын хэрэгжилтэд хяналт, шинжилгээ-үнэлгээ хийх; - төрийн байгууллагын стратегийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих - олон талт хамтын ажиллагааны хөтөлбөр, төслүүд хэрэгжүүлэх - хөгжлийн чиг хандлага, шилжилтийг чиглүүлсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх 	<p>Ерөнхий сайд, Шадар сайд</p>	<p>Төлөвлөлтийн дээд шатны удирдлага:</p> <ul style="list-style-type: none"> - Төлөвлөлтийн дээд зөвлөл (Higher Planning Council) <ul style="list-style-type: none"> o Дарга: Ерөнхий сайд o Гишүүд: хөгжлийн, сангийн, эдийн засгийн болон бусад сайд нар (тодорхой) - Мөнгө, зээлийн зохицуулалтын зөвлөл (Money-Credit Coordination Council) <ul style="list-style-type: none"> o Дарга: Шадар сайд o Гишүүд: хөгжлийн, сангийн, эдийн засгийн болон бусад сайд нар (тодорхой) - Эдийн засаг, нийгмийн зөвлөл (Economic and Social Council) <ul style="list-style-type: none"> o Төлөөлөгчид: төрийн байгууллагууд, ажил олгогчид, ажилчид, танхим, холбоод. <p>Хөгжлийн яамны бүтэц</p> <ul style="list-style-type: none"> - Макро эдийн засгийн нэгж - Орон нутгийн хөгжлийн бодлого зохицуулалт, удирдлагын 4 газар - 81 мужийг хамарсан Бүсийн хөгжлийн 26 агентлаг

	<ul style="list-style-type: none"> - бүс нутгийн хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллагууд, агентлагуудын хамтын үйл ажиллагааг хангах - хөгжлийн асуудлаарх судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулах <p>Хяналт, шинжилгээ-үнэлгээ:</p> <ul style="list-style-type: none"> - бодлогын хэрэгжилтэд хяналт, шинжилгээ-үнэлгээний ажлыг удирдан зохион байгуулна - мөн бодлого боловсруулах үе шатанд ч хийнэ. 		<ul style="list-style-type: none"> - Салбар төлөвлөлтийг хариуцсан газар <ul style="list-style-type: none"> o Нийгмийн хөгжлийн салбарын удирдах газар o Эдийн засгийн салбарын удирдах газар
--	---	--	---

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- The 'New' national development planning and global development goals: Processes and partnerships, IAdmos O.Chimhowu^aDavidHulme^bLauchlan T.Munro^c <https://www.sciencedirect.com/science/article/pii/S0305750X19300713>
- <http://www.nationalplanning.org>
- https://www.unpei.org/sites/default/files/publications/Chapter-4_0.pdf
- <https://www.sciencedirect.com/science/article/pii/S0305750X19300713?via%3Dihub>
- <https://www.constituteproject.org/search?lang=en>

UIH.MN
СУДАЛГААНЫ САН